



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/710

Булган сум

**“Уур амьсгалын өөрчлөлт, экологийн боловсрол”
олгох нэгдсэн арга хэмжээний хүрээнд
сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Уур амьсгалын өөрчлөлт, экологийн боловсрол” олгох нэгдсэн арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 9-10 нас, 11-12 нас, 13-14 насны ангиллаар зохион байгуулж, шагнал, зохион байгуулалтын зардалд 21,000,000 (хорин нэгэн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг хавсралтаар баталж, Булган аймаг, Уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 29 ны/ний өдрийн 4/910 дугаар
захирамжийн хавсралт

“Уур амьсгалын өөрчлөлт, экологийн боловсрол” олгох нэгдсэн арга хэмжээний хүрээнд
Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдах сагсан
бөмбөгийн тэмцээний шагналын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	1 дүгээр байр	6	800.000	4.800.000
2	2 дугаар байр	6	750.000	4.500.000
3	3 дугаар байр	6	700.000	4.200.000
4	Өргөмжлөл	144	3000	432.000
5	Аннос	20м2	16.400	328.000
6	Цом	6	150.000	900.000
7	Медаль	144	10.000	1.440.000
8	Шүүгч /2 өдөр/	10	105.000	2.100.000
9	Ерөнхий шүүгч /1 өдөр/	1	105.000	105.000
10	Тоглолтын бөмбөг	22	100.000	2.200.000
Нийт				21.000.000